



ХАРААТ БУС  
АУДИТОРЫН ТАЙЛАН

дөлгөөн ХАЙРХАН УУЛ  
**АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн  
хөндлөнгийн хяналтын байгууллага

## "И ЭС ЖИ ФАЙНАНС" ХК

2023 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон  
жилийн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот



**ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ  
АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол  
Ногоон шур гудамж, 101 барилгын 1204 тоот  
Утас: (976) 99055711, 99038602, 70005711  
E-mail: dulguunhairhan\_audit@mongol.net

2024. 08. 16 № 24/04-475

танаий \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г

Г

Аудитын тайлан, дүгнэлт,  
зөвлөмж хүргүүлэх тухай

“И Эс Жи файнанс” ХК болон “Дөлгөөнхайрхан уул аудит” ХХК-ийн хооронд байгуулсан 24/04-12 дугаартай Аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн “И Эс Жи файнанс” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүллээ.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б. ПУРЭВДУЛАМ.



# "И ЭС ЖИ ФАЙНАНС" ХК

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудитлагсан санхүүгийн тайлан
  - ✚ Санхүүгийн байдлын тайлан
  - ✚ Орлогын дэлгэрэнгүй тайлан
  - ✚ Өмчийн өөрчлөлтийн тайлан
  - ✚ Мөнгөн гүйлгээний тайлан
3. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
  - ✚ Компанийн үйл ажиллагааны талаарх товч танилцуулга
  - ✚ Нягтан бодох бүртгэлийн гол бодлогууд
  - ✚ Нэмэлт тодруулгууд
4. Гэрээт ажлын захидал



ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ  
АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн  
хондлонгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол  
Ногоон нутр гудамж, 101 барилгын 1204 тоот  
Утас: (976) 99055711, 99038602, 70005711  
E-mail: dulguunhairhan\_audit@mongol.net

2024.08.16 № 24/04-475

танаай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Бид “И Эс Жи файнанс” ХК-ийн /цаашид “Компани” гэх/ 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “И Эс Жи файнанс” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагынхаа энэхүү аудитын тайлангийнхаа Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Нягтлан бодогчдын ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохицтой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Тус компани нь цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

## Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайландаа орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордогтуй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

### Санхүүгийн тайландаа засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулхтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компания татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

### Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад компанийд хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохиорохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд тохиорохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн
- Компанийн тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн өрөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

Лавлагаа	(төгрөгөөр)	
	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,761.87	203,111.87
Авлага	21,600,000.00	19,600,000.00
Бусад санхүүгийн хөрөнгө	4,050,386.51	4,050,386.51
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>25,697,148.38</b>	<b>23,853,498.38</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Нийт эргэлтийн бус хөрөнгө		
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>25,697,148.38</b>	<b>23,853,498.38</b>
<b>Өр төлбөр</b>		
Нийт өр төлбөр		
<b>Эздийн өмч</b>		
Дүрмийн сан	37,401,800.00	37,401,800.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(11,704,651.62)	(13,548,301.62)
<b>Нийт эздийн өмч</b>	<b>25,697,148.38</b>	<b>23,853,498.38</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		
	<b>25,697,148.38</b>	<b>23,853,498.38</b>

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

Лавлагас	(төгрөгөөр)	
	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого	-	-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	3,513,560.99	1,843,650.00
Бусад олз (гарз)	962.10	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(3,512,598.89)	(1,843,650.00)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(3,512,598.89)	(1,843,650.00)
Зогсоосон ўйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,512,598.89)	(1,843,650.00)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Орлогын нийт дүн	(3,512,598.89)	(1,843,650.00)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 12 сарын 31</b>	37,401,800.00	(11,704,651.62)	25,697,148.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залзуулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	37,401,800.00	(11,704,651.62)	25,697,148.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(1,843,650.00)	(1,843,650.00)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>37,401,800.00</b>	<b>(13,548,301.62)</b>	<b>23,853,498.38</b>

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салишгүй хэсэг болно.



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)	
	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	5,746,324.16	1,843,650.00
Татварын байгууллагад төлсөн	2,232,763.17	-
Бусад мөнгөн зарлага	3,513,560.99	1,843,650.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(5,746,324.16)</b>	<b>(1,843,650.00)</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	2,000,000.00
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	2,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	<b>21,600,000.00</b>	-
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	21,600,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	<b>(21,600,000.00)</b>	<b>2,000,000.00</b>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Валютын ханшийн зөрүү	962.10	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>(27,345,362.06)</b>	<b>156,350.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,392,123.93	46,761.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>46,761.87</b>	<b>203,111.87</b>

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.



## ТОДРУУЛГА 1 - Товч танилцуулга

### 1.1. Компанийн тухай:

"И ЭС ЖИ ФАЙНАС" ХК Регистр: 2030136  
(Аж ахуйн нэгжийн нэр) Улсын бүртгэлийн дугаар: 9010001095  
Захирал: О.Амартүвшин Утас: 98011009 Мэйл хаяг:  
Ня-бо: Утас: Мэйл хаяг:

### Өмчийн хэлбэр

ХК, 100 хувь хувийн. Дүрмийн сан: 37,401.80 мянган төгрөг

### Компанийн байршил хаяг:

Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, жуулчны, Пиерл тауэр, 11-р давхарт, 1101 тоот

### Харилцаг санхүү, татварын байгууллага:

Чингэлтэй дүүргийн санхүү, татварын байгууллагатай харилцаг.

### 1.2. Үйл ажиллагааны чиглэл /үндсэн болон туслах үйл ажиллагаа/

Санхүүгийн зөвлөх үйлчилгээ  
Хиймэл оюун ухааны зөвлөх үйлчилгээ  
Бизнесийн зөвлөх  
И Эс Жи зөвлөх үйлчилгээ

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт, материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

## ТОДРУУЛГА 2 - Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлого

### 2.1. Санхүүгийн тайлagnalын суурь

Компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлagnalын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар аккруэл сууриар бэлтгэгдсэн байна.

Компани нь нягтлан бodoх бүртгэлээ төгрөгөөр бүртгэдэг ба нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол улсын Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.

### 2.2. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Компани нь нягтлан бodoх бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ "EXCEL" санхүүгийн програм ашиглан гаргадаг.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн байна.

### 2.3. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид ч үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл нь үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан болно.

#### 2.4. Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөрөөс бүрдэнэ.

#### 2.5. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь мөнгө, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.

#### 2.6. Авлага

Компанийн авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээний авлага, бусад авлага, татварын авлага, урьдчилж төлсөн зардал, тооцооноос бүрдэнэ. Дансын авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр тайлagnана. Бусад авлага нь байгууллага хувь хүнтэй холбоотой нэг жилээс богино хугацааны авлага хамаарч байна.

#### 2.7. Бусад санхүүгийн хөрөнгө

Богино хугацаатай хадгаламж, өрийн болон үнэт цаасны хөрөнгө оруулалт, бөгөөд СТОУС-7 санхүүгийн хэрэглүүр/тодруулга, СТОУС-9 санхүүгийн хэрэглүүр, НББОУС-32 санхүүгийн хэрэглүүр/толилуулга -ийг дагаж мөрдөнө.

#### 2.8. Өртөг, зардал

Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардлууд, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, цалин хөлсний зардал, бусад үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудаас бүрдэнэ.

#### ТОДРУУЛГА 3 - Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Төрөл	(төгрөгөөр)	
	12/31/2022	12/31/2023
Бэлэн мөнгө		
Төгрөг	46,761.87	203,111.87
Бэлэн мөнгөний үлдэгдэл	46,761.87	203,111.87
Нийт дүн	46,761.87	203,111.87

#### ТОДРУУЛГА 4 - Дансын авлага

##### 4.1 Дансын авлага

Төрөл	Дансын авлага	НАХ	Дансын авлага
Эхний үлдэгдэл	21,600,000.00		21,600,000.00
Нэмэгдсэн	-		-
Хасагдсан	2,000,000.00		2,000,000.00
-Төлөгдсөн	2,000,000.00		2,000,000.00
Нийт дүн	19,600,000.00	-	19,600,000.00

**ТОДРУУЛГА 5 -Бусад санхүүгийн хөрөнгө**

Төрөл	12/31/2022	12/31/2023	(төгрөгөөр)
Бусад хөрөнгө оруулалт	4,050,386.51	4,050,386.51	
<b>Нийт дүн</b>	<b>4,050,386.51</b>	<b>4,050,386.51</b>	

**ТОДРУУЛГА 6 - Эздийн өмч**

Төрөл	12/31/2022	12/31/2023	(төгрөгөөр)
Өмч: б) хувийн /хувьцаа хэлбэрээр /	37,401,800.00	37,401,800.00	
<b>Дүн</b>	<b>37,401,800.00</b>	<b>37,401,800.00</b>	
Тайлант үеийн ашиг (алдагдал)	(3,512,598.89)	(1,843,650.00)	
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	(8,192,052.73)	(11,704,651.62)	
<b>Хуримтлагдсан ашиг алдагдал дүн</b>	<b>(11,704,651.62)</b>	<b>(13,548,301.62)</b>	
<b>Нийт дүн</b>	<b>25,697,148.38</b>	<b>23,853,498.38</b>	

**ТОДРУУЛГА 7 - Бусад олз (гарз)**

Төрөл	12/31/2022	12/31/2023	(төгрөгөөр)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	962.10	-	
<b>Нийт дүн</b>	<b>962.10</b>	<b>-</b>	

**ТОДРУУЛГА 8 - Ерөнхий ба удирдлагын зардал**

Төрөл	12/31/2022	12/31/2023	(төгрөгөөр)
Зардлууд	Ер.Үд	Ер.Үд	
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3,500,000.00	1,813,000.00	
Бусад зардал	13,560.99	30,650.00	
<b>Нийт дүн</b>	<b>3,513,560.99</b>	<b>1,843,650.00</b>	

**ТОДРУУЛГА 9- Холбоотой талуудттай хийсэн гүйлгээ**

Тус компанийд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар холбоотой талуудттай гүйлгээ хийсэн ба тайландаа тусгасан байна.

**ТОДРУУЛГА 10- Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэх хууль**

Тус компанийд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар анхаарал татсан гүйлгээ байхгүй байна.

"И ЭС ЖИ Файнанс" ХК  
Санхүүгийн тайлангийн тодруулгүүд  
2023 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилний хувьд

**ТОДРУУЛГА 11- Болзошгүй өр төлбөр**

---

Тус компанид 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

---

**ТОДРУУЛГА 12- Балансын дараах үйл явц**

---

"И ЭС ЖИ ФАЙНАНС" ХК ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

---

Хүндэтгэсэн  
Аудитор:.....  Н.Нижмаа  
(Мэргэшсэн нягтлан бодогч)

## Гэрээт ажлын захидал

“И Эс Жи Файнанс” ХК нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон баланс, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлгэхээр билэнд хандсан билээ. Бид тус компанийн санхүүгийн тайланд аудит хийхийг хүлээн зөвшөөрч, гэрээт ажлын талаарх өөрсдийн ойлголтыг энэ захидаараа баталгаажуулахыг хүсч байгаагаа илрэхийлэхэд билэнд таатай байна.

Манай талаас үзүүлэх аудитын үйлчилгээний зорилт нь санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу явуулна. Санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илрэхийлэгдсэн гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитын ажлыг төлөвлөж, гүйцэтгэхийг уг АОУС-д заасан байдаг. Аудитын явцад санхүүгийн тайлан дахь дүн, нэмэлт тодруулгууд нь зөв эсэхийг нотлоход тестийн аргыг хэрэглэнэ. Түүнчлэн тус компанийд хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн томоохон хэмжээний тооцооллууд, түүнчлэн санхүүгийн тайлагналын байдалд бүхэлд нь үнэлэлт өгнө. Эдгээр ажлыг гүйцэтгэхэд танай компанийн ажилтнууд идэвхийлэн оролцно гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Аудитын тестийн арга бусад уламжлалт хязгаарлагдмал шинж чанар, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн ба дотоод хяналтын системийн ямар нэг уламжлалт хязгаарлагдмал байдлын улмаас зарим материаллаг зөрчлийг ч илрүүлэхгүй байх болон зарим алдаатай зүйлс гарах магадлал байхыг бид үгүйсгэхгүй. Гэхдээ ийм төрлийн алдааг аль болохоор хамгийн бага байлгахаар бид аудитын ажлыг төлөвлөж явуулна.

Бид жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ба хараат бус аудитын тайланг нэмэлт тодруулгын хамт хүргүүлж, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн орчны нийцтэй байдлыг тусгасан, дотоод хяналтын системийн эрсдэлтэй сул талуудыг үнэлж, цаашид засаж сайжруулах талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг бичиж, хуулийн болон гэрээний хугацаанд танай компанийн удирдлагад хүргүүлнэ.

Аудитын ажлын явцад бидний бэлтгэсэн ажлын баримтууд нь бидний өмч бөгөөд нууц шинж чанартай байна. Эдгээрийг бид дотоод дүрэм журмынхаа дагуу өөрсдөө хадгалах болно. Харин эдгээр баримт бичгүүдийн заримыг хууль журмын дагуу эрх бүхий компанийд гаргаж өгөх талаар бидэнд хүсэлт тавьсан тохиолдолд эдгээр баримт бичгүүдийг манай компанийн хариушлагатай ажилтны хяналтын дор гаргаж өгөх болно.

Зохих нэмэлт тодруулга бүхий санхүүгийн тайланг бэлтгэх нь компанийн удирдлагын хүлээн хариушлага гэдгийг бид сануулахыг хүсч байна. Үүнд: нягтлан бодох бүртгэлийн зохих бичилтболон дотоод хяналтыг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлгыыг сонгож хэрэглэх, байгууллагын хөрөнгийг найвдартайгаар хадгалах, хамгаалах, нөөцийг үр ашигтай зарцуулах зэрэг зүйлс багтана.

Аудитад хамрагдах санхүүгийн болон бусад бүх мэдээллийн үнэн, зөвийн баталгааг бичгээр гаргаж өгөхийг бид хүсэж байна.

Бид танай хамт олонтой хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байгаа бөгөөдаудиттай холбоотой бидний хүссэн аливаа бүртгэл, баримт, бусад мэдээллээр биднийг хангана гэдэгт итгэж байна.

Энэ захидалыг хүчингүйд тооцох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл өөр захидааар орлуулах шийдвэр гараагүй тохиолдолд энэ захидал дараагийн жилүүдэд хүчин төгөлдөр хэвээр байна.

Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг та хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэн энд гарын үсгээ зурж, баталгаажуулан манай талд ирүүлнэ үү.

**Хүндэтгэсэн:**

“Дөлгөөнхайрхан Уул Аудит” ХХК

Захирад: .....Б.Нүрэвдулам.

Аудитор.....Н.Янжмаа



**Хүлээн зөвшөөрсөн:**

“И Эс Жи Файнанс” ХК-ийн

ТУЗ дарга:.....М.Сайнболов

Нягтлан бөдөгч:.....Д.Батсайхан

